БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ТӨРИЙН АУДИТ

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

# БАЯНХОНГОР АЙМГИЙН ХҮҮХДИЙН ТЭМҮЖИН ТЕАТРЫН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**АУДИТЫН КОД:** БНА-2021/48/СТА-ТШЗ

---

| | |
|---|---|
| Баянхонгор<br>2021 он | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цэзням<br>Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn<br>Аудитор: П.Амаржаргал<br>Утас:88106992 Цахим хаяг: amarjargalp@audit.gov.mn<br>Цахим хуудас: www.audit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Агуулга


1.Төрийн аудитын санал, дүгнэлт /Эх хувь/ ..... 3

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ..... 5

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 6

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 7

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 9

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ..... 10

3.Аудитын тайлан ..... 10

3.1. Ерөнхий зүйл ..... 10

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ..... 11

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт ..... 11

3.4. Материаллаг байдал ..... 11

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ..... 12

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ..... 12

3.7. Шилэн дансны мэдээлэл ..... 14

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 14

3.9. Аудитын илрүүлэлт ..... 15

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ..... 15

Аудитын зөвлөмж ..... 15

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ..... 15

4. Менежментийн захидал ..... 15

5. Хавсралт 1.: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ..... 17




005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2021.02.25 № 2/169

танай ______________ -ны № ______________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН ХҮҮХДИЙН
ТЭМҮЖИН ТЕАТРЫН ДАРГА
Б.ГАНЧИМЭГ ТАНАА

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Аймгийн засаг дарга баталж, гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын дарга тайлагнасан байна.

Аймгийн засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтээр “А” үнэлгээтэй үнэлэгдсэн байна.

2021 А4 ТООТ

0050?0?01

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **90,558,627.00** | **88,169,577.00** |
| **33** | **АВЛАГА** | 427,133.00 | 427,133.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 427,133.00 | 427,133.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 90,131,494.00 | 87,742,444.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 6,955,690.00 | 6,099,190.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 6,955,690.00 | 6,099,190.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 83,175,804.00 | 81,643,254.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 185,100.00 | 411,100.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 5,378,100.00 | 5,103,100.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 14,860.00 | 240,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 77,597,744.00 | 75,889,054.00 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **23,358,170.84** | **25,888,990.69** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 23,358,170.84 | 25,888,990.69 |
| **392** | **Биет хөрөнгө** | 19,597,070.84 | 22,127,890.69 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 88,847,451.00 | 90,607,251.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -84,770,250.83 | -85,731,421.05 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 99,296,396.00 | 109,549,396.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -85,603,250.14 | -94,091,135.26 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2,474,500.00 | 2,474,500.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -1,162,775.19 | -1,365,700.00 |
| 39217 | Ном | 515,000.00 | 685,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 3,761,100.00 | 3,761,100.00 |
| 39301 | Программ хангамж | 550,000.00 | 550,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -550,000.00 | -550,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 3,761,100.00 | 3,761,100.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **113,916,797.84** | **114,058,567.69** |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **5,463,557.00** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 5,463,557.00 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 5.463,557.00 | 00.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 5,300,712.00 | 00.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 8,460.00 | 00.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 154,385.00 | 00.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 154,385.00 | 00.00 |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **108,453,240.84** | **114,058,567.69** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 108,453,240.84 | 114,058,567.69 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 137,949,437.69 | 137,949,437.69 |
| 51101 | Өмч: - төрийн | 137,949,437.69 | 137,949,437.69 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -52,597,557.85 | -46,992,231.00 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -52,597,557.85 | -52,597,557.85 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 5,605,326.85 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 23,101,361.00 | 23,101,361.00 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **113,916,797.84** | **114,058,567.69** |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **213,536,900.00** | **473,833,900.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **20,053,000.00** | **980,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 20,053,000.00 | 980,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 20,053,000.00 | 980,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 20,053,000.00 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 00.00 | 980,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **193,483,900.00** | **472,853,900.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 38,164,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 5,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 33,164,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 193,483,900.00 | 434,689,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 193,483,900.00 | 434,689,900.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **184,096,686.18** | **468,228,573.15** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **184,096,686.18** | **468,228,573.15** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 183,596,686.18 | 462,893,509.13 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 107,640,436.00 | 278,420,665.00 |
| 210101 | Үндсэн цалин | 107,640,436.00 | 278,420,665.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 13,460,142.00 | 34,078,158.98 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,460,142.00 | 34,078,158.98 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 40,079,051.00 | 80,058,392.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,248,683.00 | 1,626,556.00 |
| 210302 | Түлш, халаалт | 35,518,560.00 | 71,753,220.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,311,808.00 | 6,678,616.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,355,220.00 | 6,931,068.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 554,160.00 | 1,256,890.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 118,680.00 | 4,009,538.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 201,630.00 | 421,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 150,000.00 | 255,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 330,750.00 | 988,040.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 856,100.00 | 4,618,360.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 100,000.00 | 100,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 756,100.00 | 4,518,360.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,180,000.00 | 2,067,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,180,000.00 | 2,067,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 13,259,800.00 | 47,067,485.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,959,800.00 | 46,526,185.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | 300,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 241,300.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5,765,937.18 | 9,651,980.15 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 5,765,937.18 | 9,651,980.15 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 500,000.00 | 5,335,064.02 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 500,000.00 | 1,500,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 500,000.00 | 1,500,000.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 2134 | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 3,835,064.02 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 3,823,729.02 |
| 213404 | Хөрөнгийн | 00.00 | 11,335.00 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **29,440,213.82** | **5,605,326.85** |
| 5 | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **29,440,213.82** | **5,605,326.85** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **418,284,700.00** | **472,853,900.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **52,065,700.00** | **00.00** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 52,065,700.00 | 00.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 52,065,700.00 | 00.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 52,065,700.00 | 00.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **366,219,000.00** | **472,853,900.00** |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 38,164,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 5,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 33,164,000.00 |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 366,219,000.00 | 434,689,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 366,219,000.00 | 434,689,900.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **418,284,700.00** | **461,651,100.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **418,284,700.00** | **461,651,100.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **414,169,215.00** | **456,316,035.98** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 217,063,000.00 | 281,772,000.00 |
| 210101 | Үндсэн цалин | 214,161,085.00 | 281,772,000.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,125,000.00 | 00.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 776,915.00 | 00.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 24,768,300.00 | 36,027,535.98 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,842,400.00 | 25,076,862.23 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,981,500.00 | 2,798,563.59 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,585,200.00 | 2,086,821.34 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 396,300.00 | 551,685.40 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,962,900.00 | 5,513,603.42 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 78,999,081.00 | 80,058,392.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,409,305.00 | 1,626,556.00 |
| 210302 | Түлш, халаалт | 69,966,160.00 | 71,753,220.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,623,616.00 | 6,678,616.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 4,568,834.00 | 7,319,913.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,034,100.00 | 1,543,550.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,403,000.00 | 4,017,998.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 411,734.00 | 421,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 180,000.00 | 350,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 540,000.00 | 986,765.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| **2105** | **Нормативд зардал** | 00.00 | 540,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 540,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,099,900.00 | 4,568,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 100,000.00 | 100,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,999,900.00 | 4,468,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,648,400.00 | 2,067,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,648,400.00 | 2,067,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 84,021,700.00 | 43,962,295.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 83,456,500.00 | 43,420,995.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | 300,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 265,200.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 241,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **4,115,485.00** | **5,335,064.02** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 500,000.00 | 1,500,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 500,000.00 | 1,500,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 3,615,485.00 | 3,835,064.02 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6,285.00 | 3,823,729.02 |
| 213404 | Хөрөнгийн | 3,609,200.00 | 11,335.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **00.00** | **11,202,800.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **11,202,800.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **11,202,800.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 11,202,800.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 11,202,800.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **-11,202,800.00** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C08 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 137,949,437.69 | 23,101,361.00 | -52,597,557.85 | 00.00 | 108,453,240.84 |
| D01 | 2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | 137,949,437.69 | 23,101,361.00 | -52,597,557.85 | 00.00 | 108,453,240.84 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 137,949,437.69 | 23,101,361.00 | -52,597,557.85 | 00.00 | 108,453,240.84 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 5,605,326.85 | 00.00 | 5,605,326.85 |
| D09 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 137,949,437.69 | 23,101,361.00 | -46,992,231.00 | 00.00 | 114,058,567.69 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 434,689,900.00 | 430,866,170.98 | 3,823,729.02 | 99.12 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 434,689,900.00 | 430,866,170.98 | 3,823,729.02 | 99.12 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 433,189,900.00 | 429,366,170.98 | 3,823,729.02 | 99.12 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 281,772,000.00 | 281,772,000.00 | 0.00 | 100.00 |
| 210101 | Үндсэн цалин | 281,772,000.00 | 281,772,000.00 | 0.00 | 100.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 36,046,700.00 | 36,027,535.98 | 19,164.02 | 99.95 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,775,900.00 | 25,076,862.23 | -300,962.23 | 101.21 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,817,700.00 | 2,798,563.59 | 19,136.41 | 99.32 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,254,200.00 | 2,086,821.34 | 167,378.66 | 92.57 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 563,500.00 | 551,685.40 | 11,814.60 | 97.90 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,635,400.00 | 5,513,603.42 | 121,796.58 | 97.84 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 80,280,200.00 | 80,058,392.00 | 221,808.00 | 99.72 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,902,500.00 | 1,626,556.00 | 275,944.00 | 85.50 |
| 210302 | Түлш, халаалт | 71,754,000.00 | 71,753,220.00 | 780.00 | 100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,623,700.00 | 6,678,616.00 | -54,916.00 | 100.83 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,328,800.00 | 7,319,913.00 | 8,887.00 | 99.88 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,544,300.00 | 1,543,550.00 | 750.00 | 99.95 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,018,000.00 | 4,017,998.00 | 2.00 | 100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 421,600.00 | 421,600.00 | 0.00 | 100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 350,000.00 | 350,000.00 | 0.00 | 100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 994,900.00 | 986,765.00 | 8,135.00 | 99.18 |
| **2105** | **Нормативд зардал** | 540,000.00 | 540,000.00 | 0.00 | 100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 540,000.00 | 540,000.00 | 0.00 | 100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,568,500.00 | 4,568,500.00 | 0.00 | 100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 100,000.00 | 100,000.00 | 0.00 | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,468,500.00 | 4,468,500.00 | 0.00 | 100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,067,400.00 | 2,067,400.00 | 0.00 | 100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,067,400.00 | 2,067,400.00 | 0.00 | 100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 20,586,300.00 | 17,012,430.00 | 3,573,870.00 | 82.64 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 20,021,100.00 | 16,471,130.00 | 3,549,970.00 | 82.27 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | 300,000.00 | 0.00 | 100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 265,200.00 | 241,300.00 | 23,900.00 | 90.99 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1500000.00 | 1500000.00 | 0.00 | 100.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,500,000.00 | 1,500,000.00 | 0.00 | 100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,500,000.00 | 1,500,000.00 | 0.00 | 100.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 434,698,900.00 | 430,866,170.98 | 3,832,729.02 | 99.12 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 434,698,900.00 | 430,866,170.98 | 3,832,729.02 | 99.12 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 434,698,900.00 | 430,866,170.98 | 3,832,729.02 | 99.12 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 20.00 | 26.00 | -6.00 | 130.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 0.00 | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 11.00 | 18.00 | -7.00 | 163.64 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 08.00 | 07.00 | 1.00 | 87.50 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **20.00** | **26.00** | -6.00 | 130.00 |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 13.00 | 18.00 | -5.00 | 138.46 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 08.00 | 08.00 | 0.00 | 100.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **0.00** | **38,152,665.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **0.00** | **38,152,665.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 0.00 | 38,152,665.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 0.00 | 38,152,665.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 0.00 | 38,152,665.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 32893265.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 32,893,265.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 0.00 | 7,209,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 5,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 0.00 | 20,684,265.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга Б.Ганчимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн хадгалалт хамгаалалт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 24-өөс 2021 оны 02 дугаар сарын 25–ны хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал хариуцаж хэрэгжүүлэв.



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театр нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 104 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

## 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- "Мэргэжлийн чадварлаг боловсон хүчинтэй, чанартай үйлчилгээ таатай орчин технологи шинэчлэлд тулгуурлаж үзэгчид, суралцагч хүүхдийн эрэлт хэрэгцээг хангаж хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх, мэргэжлийн чиг баримжаа олгож, тэдэнд урлагийн боловсролоор дамжуулан хүүхдийн бахархалт бүтээл болгох, орчин үеийн болон сонгодог болон сонгодог, ардын өв соёл, биет болон биет бус өвийг сэргээн өвлүүлэх, уран бүтээлийг нийтэд түгээн дэлгэрүүлэх замаар нийгмийн оюун санааны хөгжилд бодитойгоор хувь нэмрээ оруулах" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Соёлын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль

## 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2020 онд харьяа орон нутаг дахь Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "Дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 3 дугаар улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 318454.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 6369.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 468228.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 9364.6 мянган төгрөгөөр тооцов.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 114058.5 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 141.7 мянган төгрөгөөр буюу 0.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, Засгийн газрын оролцоо данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 90558.63 | 88169.58 | -2389.05 |
| Мөнгөн хөрөнгө | 0.00 | 0.00 | 0.00 |
| Авлага | 427.13 | 427.13 | 0.00 |
| Урьдчилгаа | 0.00 | 0.00 | 0.00 |
| Бараа материал | 90131.49 | 87742.44 | -2389.05 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 23358.17 | 25888.99 | 2530.82 |
| Үндсэн хөрөнгө | 195444.45 | 207627.25 | 12182.80 |
| Хуримтлагдсан элэгдэл | -5765.94 | -9651.98 | -3886.04 |
| Нийт хөрөнгө | 113916.80 | 114058.57 | 141.77 |
| Өр төлбөр | 5463.56 | 0.00 | -5463.56 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 108453.24 | 114058.57 | 5605.33 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 113916.80 | 114058.57 | 141.77 |

*Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан*

Өмнөх онд ажиллагсадтай холбоотой авлага дансны үлдэгдэл 427.1 байсан ба тайлант онд тус авлагыг барагдуулж ажиллаагүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 87742.4 мянган төгрөг болж 2389.0 мянган төгрөгөөр буурсан нь 13120.3 мянган төгрөгийн бараа материал акталж утгасантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 207627.2 мянган төгрөг болж 12182.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 12182.8 мянган төгрөгийн хөрөнгийг орлогоор бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн машин тоног төхөөрөмжийн данс нь 1759.8 мянга, тавилга хэрэгслийн данс 10253.0 мянга, номын фонд 170.0 мянга нийт 12182.8 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авч үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 114058.5 мянган төгрөг болж 5605.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн 5605.3 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 473833.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 260297.0 мянган төгрөгөөр буюу 55 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан орон нутгийн төсвөөс санхүүжих санхүүжилт, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого, дээд шатны төсөв захирагчаас олгосон санхүүжилтийн орлого тус тус нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлж байна. Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого өмнөх оноос 33164.0 мянга, дээд шатны төсөв захирагчаас олгосон санхүүжилт 5000.0 мянга, орон нутгийн төсвөөс санхүүжих санхүүжилт 241206.0 мянган төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал 468228.5 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 284131.8 мянган төгрөгөөр буюу 61 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал,хангамж бараа материалын зардал, эд хогшил урсгал засварын зардал, томилолт зочны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

### 3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 369484.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 369484.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 75005.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 444489.9 мянган төгрөгөөр баталсан байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр анх 44489.9 мянган төгрөгийн төсөв батлагдаж 2020 оны 9-р сард тодотгол хийн 434689.9 мянган төгрөг болж 9800.0 мянган төгрөгөөр буурсан бол тайлант оны 12-р сарын байдлаар 434689.9 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан орон тоо 20 байхаас 26 орон тоотой ажиллаж байгаа нь аймгийн Засаг даргын 2017 оны 09 дүгээр 13-ны өдрийн А/640 тоот захирамжаар тус байгууллагын бүтэц орон тоог 55 байхаар баталж өгсөн боловч тус орон тоогоор төсөв батлагдаж ирэхгүй байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 434698.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 430866.1 мянган төгрөгийг зарцуулж 3832.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 430866.1 мянган төгрөг буюу 99.1 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтол зардлыг 221.8 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийг 3573.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 71702 хөтөлбөрийн 80101 арга хэмжээ 3823.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Хүснэгт.2 Төсвийн гүйцэтгэлийн тайлан/хөтөлбөр арга хэмжээгээр/ мянган.төг

| № | | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| Хөтөлбөр 71702 | | | | | | |
| | | Нийт дүн | 434,689.90 | 430,866.17 | 3,823.73 | 99.12 |
| | 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 433,189.90 | 429,366.17 | 3,823.73 | 99.12 |
| 1 | 210101 | Үндсэн цалин | 281,772.00 | 281,772.00 | 0.00 | 100.00 |
| 2 | 210201 | Нийгмийн даатгалын шимтгэл | 24,775.90 | 25,076.86 | -300.96 | 101.21 |
| 3 | 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,817.70 | 2,798.56 | 19.14 | 99.32 |
| 4 | 210203 | ҮОМШ-ний даатгал | 2,254.20 | 2,086.82 | 167.38 | 92.57 |
| 5 | 210204 | Ажилгүйдлийн даатгал | 563.50 | 551.69 | 11.81 | 97.90 |
| 6 | 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,635.40 | 5,513.60 | 121.80 | 97.84 |
| 7 | 210301 | Гэрэл, цахилгаан | 1,902.50 | 11,192.95 | -9,290.45 | 588.33 |
| 8 | 210302 | Түлш, халаалт | 71,754.00 | 62,186.82 | 9,567.18 | 86.67 |
| 9 | 210303 | Цэвэр, бохир ус | 6,623.70 | 6,678.62 | -54.92 | 100.83 |
| 10 | 210401 | Бичиг хэрэг | 1,544.30 | 1,543.55 | 0.75 | 99.95 |
| 11 | 210402 | Тээвэр, шатахуун | 4,018.00 | 4,018.00 | 0.00 | 100.00 |
| 12 | 210403 | Шуудан, холбоо, интернэт | 421.60 | 421.60 | 0.00 | 100.00 |
| 13 | 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон | 350.00 | 350.00 | 0.00 | 100.00 |
| 14 | 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, | 994.90 | 986.77 | 8.13 | 99.18 |
| 15 | 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 540.00 | 540.00 | 0.00 | 100.00 |
| 16 | 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 100.00 | 100.00 | 0.00 | 100.00 |
| 17 | 210604 | Урсгал засвар | 4,468.50 | 4,468.50 | 0.00 | 100.00 |
| 18 | 210702 | Дотоод албан томилолт | 2,067.40 | 2,067.40 | 0.00 | 100.00 |
| 19 | 210801 | Бусад нийтлэг АҮТХураамж | 20,021.10 | 16,471.13 | 3,549.97 | 82.27 |
| 20 | 210802 | Аудит бат, зээрэглэл тогтоох | 300.00 | 300.00 | 0.00 | 100.00 |
| 22 | 210806 | Мэдээлэл технолгийн үйлчилгээ | 265.20 | 241.30 | 23.90 | 90.99 |
| | 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардал | 1,500.00 | 1,500.00 | 0.00 | 100.00 |
| 53 | 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшууллын зардал | 1,500.00 | 1,500.00 | 0.00 | 100.00 |

*Эх сурвалж: Байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан*

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 19690.4 мянга, тус байгууллагаас жил бүр гадаадын 7 улс, орны уран зураачдыг оролцуулсан уран зургийн уралдаан зохион байгуулдаг бөгөөд үүнтэй холбоотой уран зургийн гэр галерейтай болох хүсэлтийг Швейцарын хөгжлийн агентлагт тавьж хүсэлтийн дагуу тус агентлагаас Гэр галерей байгуулахад шаардлагатай хөрөнгийг санхүүжилтэд 13473.6 мянга, "Сархадаас сална хө" аяны хүрээнд аймгийн ЗДТГ-аас 20 контент хийх зардалд 5000.0 мянган төгрөг нийт 38164.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр 10216.8 мянган төгрөгийн гэр тохижуулсан, холбогдох зардалд зарцуулсан байна.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүснэгт.3 Шилэн дансны мэдээлэл оруулсан байдал

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 5 | 1 | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | 0 | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 4 | 0 | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 12 | 24 | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 40 | 56 | |
| | Нийт | 27 | 151 | 65 | 81 | 2 |

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл мэдээлбэл зохих 149 мэдээллээс Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр,Хагас жилээр,Улирал бүр,Сар бүр) мэдээллийг 2,5-8, 10-12-р саруудад 434440.0 мянган төгрөгийн 8 мэдээлэл, Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр) мэдээллийн 7 мэдээ, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр) мэдээллийг 217760.2 мянган төгрөгийн 7 мэдээлэл, Хөрөнгө оруулалт худалдан авалттай холбоотой 23 мэдээлэл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл (Тухай бүр) мэдээллийг 2,5,7,8,10-12-р сарууддад, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (Тухай бүр) мэдээлэл, Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт (Тухай бүр) мэдээлэл, Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт (Сар бүр) мэдээлэл, Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн (Тухай бүр) мэдээллийг тус бүр 2,5,7,8,10-12-р сарууддад 36 мэдээлэл нийт 217760.2 мянган төгрөгийн 81 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

## 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллагын өмнөх оны санхүүгийн тайлангийн зөвлөмжийн хэрэгжилтийг 2020 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 44 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7097.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 497.8 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 6600.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгч, алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 1 зөрчилд зөвлөмж хүргүүллээ.

### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 7097.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрч 497.8 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 6600.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгөв. Үүнд:

**1.** Цалингийн давтан тооцоолол хийхэд 2 сахилгын шийтгэлтэй албан хаагчид 497.0 мянган төгрөгийн урамшуулалт цалинг олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын" 2.7. "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" гэсэн заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**<u>Шийдвэрлэсэн нь:</u>** Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

**2.** Хөрөнгийн тооллого бүртгэл тулгахад үндсэн хөрөнгийн шинж чанартай 6600.0 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388-р тушаалаар батлагдсан журмын 1-р хавсралт "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Албан шаардлага өгөх

### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар анхаарч

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

**1. *Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал***

*<u>1.1 Илрүүлэлт:</u>* Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл мэдээлбэл зохих 149 мэдээллээс 81 төрлийн 217760.2 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4 " Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтыг зөрчсөн.

*<u>1.2 Эрсдэл:</u>* Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй байх.

*<u>1.3 Өгсөн зөвлөмж:</u>* Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 .дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4 " Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсний дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан бусад хяналт шалгалтын дүнг хугацаанд нь мэдээлж хуулийг хэрэгжүүлж ажиллах.

*1.4 <u>Байгууллагаас өгсөн хариу тайлбар:</u>Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:
АУДИТОР П.АМАРЖАРГАЛ 2021.02.25

Анхан шатанд хянасан:
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЭНЯМ 2021.02.25

Хоёр дахь шатанд хянасан:
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ 2021.02.25

6417143544
БЮА0067 9007423

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 5. Хавсралт 1: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо | Аудитын нэр: | Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2020 | | | БНА-2021/48/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | | Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театр | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Цалингийн давтан тооцоолол хийхэд 2 сахилгын шийтгэлтэй албан хаагчид 497.0 мянган төгрөгийн урамшуулалт цалинг олгосон байна | 497.8 | Төлбөрийн акт тогтоох | Дарга, нягтлан бодогч | Б.Ганчимэг У.Дагийран |
| 2 | Хөрөнгийн тооллого бүртгэл тулгахад үндсэн хөрөнгийн шинж чанартай 6600.0 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн байна. | 6600.0 | Албан шаардлага өгсөн | Дарга, нягтлан бодогч | Б.Ганчимэг У.Дагийран |
| 3 | Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл мэдээлбэл зохих 149 мэдээллээс 217760.2 мянган төгрөгийн 82 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна, | - | Зөвлөмж өгсөн | Дарга, нягтлан бодогч | Б.Ганчимэг У.Дагийран |
| **ДҮН** | | **7097.8** | | | |

oOo



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ